



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар A/176

Хэрлэн сүм

Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх,  
урьдчилан сэргийлэх арга хэмжээг  
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоол, Улсын Онцгой Комиссын 2022 оны 02 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус аймгийн нутаг дэвсгэрт мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалт нэмэгдэх эрсдэлтэй байгаа тул уг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулж, тэмцэх бэлэн байдлыг хангаж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мянган өвчинтэй тэмцэх зааврын дагуу холбогдох арга хэмжээг цаг алдалгүй оновчтой хэрэгжүүлэх, халдвартыг голомтод нь цомхтон дараах, цаашид үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг эрүүл мэндийн үзлэг, тандалтыг шуурхай зохион байгуулж, мэргэжлийн анги, мэргэжлийн багийн үүрэг, хариуцлагыг эрчимжүүлж ажиллахыг Баян-Адарга, Галшар, Өмнөдэлгэр сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3.Гоц халдварт өвчнийг бүрэн хяналтад авах хүртэлх хугацаанд хүн, мал, тээврийн хэрэгсэл, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний шилжилт хөдөлгөөнийг хориглосон хорио цээрийн дэглэм хэрэгжиж буй сумдад хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Д.Батхүү), Онцгой байдлын газар (хурандаа Ж.Эрдэнэбат)-т тус тус үүрэг болгосугай.

2.

4. Гоц халдварт өвчний тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээнд гарсан зардлыг орон нутгийн батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5. Гоц халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх, өвчний нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээллээр холбогдох байгууллагуудыг хангах, уг өвчний хор хохирол, халдвар дамжих зам болон түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар гаргасан журам зааврын талаар малчид иргэдийг мэдээ, мэдээллээр хангах, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг сумдын Засаг дарга нар, Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт гавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

